



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/170

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төрийн албаны хурд бүтээмж, цахимжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлсэн И-оффис программд өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн санд холбох ажлыг зохион байгуулсугай.

2. Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санд холбоход шаардагдах 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Цахим Булган хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010222